



ЕАБХАБ-ЫН АИХЭГ-ААС ТОМИЛОГДСОН СОНГУУЛЬ АЖИГЛАХ ХОРОО Ерөнхийлөгчийн Сонгууль — Монгол Улс, 2013 оны 6 сарын 26 өдөр

Урьдчилсан Үр Дүн болон Дүгнэлтийн Тухай Мэдэглэл

Улаанбаатар хот, 2013 оны 6 сарын 27 өдөр – Монгол Улсын Гадаад харилцааны яамны урилга болон 2013 оны 3 дугаар сарын 4-8-ны хооронд явуулсан Хороо байгуулах хэрэгцээг үнэлэх судалгааны зөвлөмжийг үндэслэн 6 дугаар сарын 26 өдрийн Ерөнхийлөгчийн сонгуулийг ажиглах ЕАБХАБ-ын Ардчилсан Институт, Хүний Эрхийн Газар (ЕАБХАБ-ын АИХЭГ)-ын Сонгууль Ажиглах хороо (САХ)-г томилов.

Монгол Улс өнгөрсөн 2012 оны 11 дүгээр сарын 21-нд ЕАБХАБ-ын бүрэн эрхт 57 дахь гишүүн орон болсон тул ЕАБХАБ-ын бүх амлалтууд, үүний дотор ардчилсан сонгуультай холбоотой амлалтуудыг биелүүлэх үүрэг хүлээсэн. ЕАБХАБ-ын Монгол Улсад хийсэн анхны сонгуулийн ажиглалт нь 6 дугаар сарын 26 өдрийн Ерөнхийлөгчийн сонгууль байлаа. Энэхүү сонгуулийг ардчилсан сонгуулийн төлөөх ЕАБХАБ-ын амлалтууд болон олон улсын стандарт, түүнчлэн үндэсний хууль тогтоомжийн мөрдөлт, сахин биелэлт дээр үндэслэн үнэлсэн. Энэхүү урьдчилсан үр дүн болон дүгнэлтийн тухай мэдэгдлийг үйл явц дуусахаас өмнө танилцуулдаг. Сонгуулийн эцсийн үнэлгээ нь сонгуулийн үйл явцын үлдсэн үе шат, тухайлбал сонгуулийн үр дүн болон санал авах өдрөөс хойш гарч болох өргөдөл гомдлыг шийдвэрлэхтэй холбоотой асуудлуудаас хамаарна. ЕАБХАБ-ын АИХЭГ нь цаашид сайжруулах асуудлуудыг багтаасан эцсийн дэлгэрэнгүй тайланг сонгуулийн үйл явц дууссанаас хойш найм орчим долоо хоногийн дараа гаргадаг.

Урьдчилсан Дүгнэлт

6 дугаар сарын 26-ны өдөр болж өнгөрсөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль нь хуулийн тодорхой хязгаарлалтаас болж хэвлэл мэдээлэлийнхнээс сонгогчдод хангалттай мэдээлэл хүргэж чадаагүй хэдий ч эрх чөлөөг хүндэтгэн дээдлэн явагдсан өрсөлдөөнт сонгуулийн сурталчилгаатай байснаараа онцлог байлаа. Сонгуулийн хууль тогтоомжийг саяхан сайжруулсан хэдий ч ойлгомжгүй, зарим тохиолдолд хоорондоо зөрчилдсөн заалтууд байгаагаас гадна өргөдөл гомдлыг үр дүнтэй шийдвэрлэх зохицуулалт хангалтгүй байна. Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотой техникийн асуудлуудыг Сонгуулийн ерөнхий хороо (СЕХ) үр дүнтэй удирдан явуулсан боловч сонгуулийн хууль тогтоомжийг жигд, нэгдсэн байдлаар хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг байнга авч хэрэгжүүлсэнгүй. Сонгуулийн санал авах өдөр сонгогчид саналаа чөлөөтэй өгсөн бөгөөд саналаа нууцаар гаргах зарчим байнга хангагдаагүй хэдий ч ажиглалт хийгдсэн сонгуулийн хороодын 99 хувь нь эерэг үнэлгээ авлаа.

Энэ удаагийн Ерөнхийлөгчийн сонгууль нь олон нийтээр хэлэлцүүлэлгүйгээр 2012 оны 12 дугаар сард шинэчлэн баталсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Сонгуулийн тухай хууль (МУЕСТХ)-ийн дагуу явагдсан. Шинэ МУЕСТХ нь өмнөх хуулиасаа сайжирсан боловч орхигдсон асуудлууд, тодорхойгүй зүйл заалтууд, түүнчлэн үл нийцэх, ялангуяа сонгуулийн сурталчилгааны зохицуулалттай холбоотой хязгаарлалтууд байна. ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-ны ажиглалтаар хуулийн эдгээр дутагдалтай байдал нь хуулийг жигд бус тайлбарлах, мөн хэрэглэхэд хүргэж байна. Түүнчлэн уг хуулийг боловсруулж баталсан байдал нь сонгуулийн үйл явцад итгэх итгэлийг бууруулсан нь ажиглагдаж байна.

Бүх шатны сонгуулийн хороод сонгуулийн техникийн асуудлуудыг үр дүнтэй удирдсан бөгөөд ерөнхийдөө сонгуулийн оролцогч талуудын итгэлийг хүлээсэн. СЕХ, аймаг нийслэлийн болон

сум, дүүргийн сонгуулийн хороо (АНСХ ба СДСХ)-д шаардлагатай бэлтгэл ажлыг хуульд заасан хугацаанд нь хангасан. Гэхдээ эдгээр доод шатны сонгуулийн хороодын ажилд зориулсан иж бүрэн дүрэм журмыг СЕХ батлаагүй. СЕХ нь сонгуулийг удирдан явуулах үүрэгтэй байгууллага хэдий ч сонгуулийн хууль тогтоомжийн нэг мөр, жигд хэрэгжилтийг хангах үйл явцын тодорхой асуудлуудыг зохицуулахад шаардлагатай алхмуудыг байнга авч хэрэгжүүлээгүй. СЕХ-ны үйл ажиллагаа нь байнга ил тод, нээлттэй байсангүй. Мөн зарим хурлынхаа зарыг ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-нд мэдээлээгүй болно. Бүх шатны сонгуулийн хороодын гишүүдийг төрийн албан хаагчдын дундаас сонгосон. Сонгуулийн хороодод Төрийн албан хаагчийг ямар шалгуураар сонгон ажиллуулах тухай хуулинд тодорхой тусгаагүй бөгөөд ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-ны урт хугацааны зарим ажиглагчид (УХА-чид) тайландаа сонгуулийн захиргааны бүх шатанд, үүний дотор удирдах албан тушаалуудад АН-тай холбоотой төрийн албан хаагчид томилогдсон тухай итгэл үнэмшилтэй мэдээллүүдийг дурдсан.

Монгол Улсын сонгогчийн бүртгэл нь идэвхгүй, мөчлөгт бөгөөд Иргэний бүртгэл, мэдээллийн улсын сангийн мэдээлэлд үндэслэгддэг. Уулзаж ярилцсан улс төрийн намуудын хүмүүс ерөнхийдээ сонгогчийн бүртгэлийн системд итгэлтэй байгаагаар илэрхийлсэн. Гэвч сонгогчийн нэрсийн жагсаалтын үйл ажиллагаанд оролцож байгаа эрх бүхий байгууллагуудын уялдаа муугаас болж сонгогчийн нэрсийн жагсаалтын чанарт сөргөөр нөлөөлсөн. Нэрсийн жагсаалтыг зарим нэг СХХ санал авах байранд олон нийтэд зориулан ил тавиагүй байсан хэдий ч сонгогчийн хүсэлтээр гаргаж өгөх боломжтой байв.

Ерөнхийлөгчийн сонгуульд гурван нэр дэвшигч өрсөлдсөн. Үндсэн хууль болон МУЕСТХ-иар парламент дахь улс төрийн нам, эвслийн Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлэх эрхэнд хязгаар тавьдаг. 1990 оны ЕАБХАБ-ын Копенгагены баримт бичгийн 7.5 дахь хэсэгт зааснаас ялгаатай нь ерөнхийлөгчийн сонгуульд хувь хүн бие даан нэр дэвших боломжгүй юм. Ерөнхийлөгчид нэр дэвшигчид тавих зарим шаардлагууд нь хэтэрхий хязгаарлагдмал бөгөөд ЕАБХАБ-ын амлалт болон олон улсын бусад стандартуудтай нийцэхгүй байна.

Сонгуулийн сурталчилгааны орчин өрсөлдөөнтэй, эвлэлдэн нэгдэх, цуглаан, хөдөлгөөн хийх үндсэн эрх, эрх чөлөөнд хүндэтгэлтэй хандсан байдалтай байлаа. Өрсөлдөгчид сонгуулийн сурталчилгаагаар саад тотгоргүй явуулсан бөгөөд тэдний зохион байгуулсан цуглааны үеэр ямар нэг осол зөрчил гараагүй болно. Зарим улс төрийн намууд Санал тоолох автомат машин (СТАТ)-ны найдвартай ажиллагаанд эргэлзэж байгаагаар илэрхийлсэн нь сонгуулийн сурталчилгааны үед асуудал болж байлаа. Гурван нэр дэвшигч гурвуулаа МУЕСТХ-ийг зөрчин санхүүгийн чанартай амлалтууд өгсөн. Сонгуулийн сурталчилгаа идэвхтэй өрнөж байсан боловч нэр дэвшигчид, эсхүл тэдний төлөөлөгчдийн дунд амьд, нүүр тулсан хэлэлцүүлэг мэтгэлцээн дутмаг байлаа.

Эрх зүйн орчин нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хангадаг. Хэвлэл мэдээллийн зах зээл улс төрийн олон ургалч үзлийг тодорхой түвшинд зөвшөөрдөг ба энэ байдлаас болж маш олон тооны хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь улс төрийн тоглогчдын шууд болон шууд бус эзэмшилд байдаг бөгөөд мэдээний хөтөлбөрийн агуулгад эзэмшигч хөндлөнгөөс нөлөөлдөг. Энэ нь эрхлэгчийн бие даасан хараат бус байдлыг устгадаг. Хэвлэл мэдээллийн цахим хэрэгслээр төлбөртэй болон төлбөргүй явуулах улс төрийн сурталчилгаатай холбоотой хуулийн заалтууд их байна. Хэдий тийм боловч нэр дэвшигчид хоорондоо мэтгэлцэх, мөн нэр дэвшигчдээс асуулт асуух боломж сэтгүүлчид, шинжээчид болон олон нийтэд олгосон хөтөлбөрүүд бараг байсангүй. Энэ байдал нь хэвлэл мэдээллийнхэн өөрсдийн чиг үүргээ биелүүлэн сонгуулийн асуудлаар болон улс төрийн сонголтуудын талаар ул суурьтай, хүчтэй олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх боломжийг олгосонгүй.

МУЕСТХ нь хариуцлагын нэг шатлалын бүтэцтэй өргөдөл, гомдол шийдвэрлэх үйл ажиллагааг нарийн тодорхойлоогүй байна. Сонгуулийн маргааныг шийдвэрлэх үйл явцын талаар оролцогч талуудын хоорондын ойлголцол муу, дагаж мөрдөх хууль тогтоомжийн тайлбар жигд бус байна. Мөн шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх хугацаа нь ЕАБХАБ-ын 1990 оны Копенгагены баримт бичгийн 5.10-т заасан шаардлагыг хангахгүй байна. Харамсалтай нь СЕХ, эсвэл цагдаагийн байгууллагад ирүүлсэн өргөдөл гомдлыг үзэж танилцах боломжоор ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ сайн хангагдаагүй болохоор шийдвэрлүүлэхээр гаргасан өргөдөл гомдол болон тэдгээрийн шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж чадаагүй болно.

Сонгуулийн санал авах өдөр тайван, амгалан болж өнгөрлөө. СЕХ-ноос мэдээлснээр сонгуулийн ирц 64,8 хувьтай байлаа. Сонгуулийн санал өгөх ажиллагааг ажиглах Ажиглалт хийгдсэн санал авах байруудад бараг бүгдээрээ эерэг үнэлгээ авлаа. Холбогдох дүрэм журмыг ерөнхийдөө дагаж мөрдсөн боловч сонгогч нууцаар саналаа гаргах боломж зуун хувь хангагдаагүй. Зарим нэг зөрчлийг үл тооцвол сонгуулийн санал тоолох үйл явц ерөнхийдөө эерэг үнэлгээ авсан. Олон СДСХ-дын хүснэгт гаргах үйл явц зохион байгуулалт, ил тод байдал тааруу байв. СЕХ-ноос сонгуулийн урьдчилсан дүнг 6 сарын 27-ны өдөр мэдээлсэн. Гэхдээ үүнийг сонгуулийн санал авах хэсгийн хороод дээр задлаагүй.

УРЬДЧИЛСАН ҮР ДҮН

Үндэслэл

Үндсэн хуулийн заалттай уялдуулан Монгол Улсын Их Хурал (парламент) Ерөнхийлөгчийн сонгуулийг 2013 оны 6 дугаар сарын 26-ны өдөр товлон зарласан. 2012 оны 7 дугаар сард явагдсан сонгуулийн үр дүнд парламент дахь 76 суудлын 34 суудлыг Ардчилсан нам (Ерөнхий сайд Норовын Алтанхуягын удирдсан АН), 11 суудлыг Шударга ёс эвсэл (Ерөнхийлөгч асан Намбарын Энхбаярын удирдсан)¹, 2 суудлыг Иргэний Зориг-Ногоон нам (УИХ-ын гишүүн, Байгаль орчин, Ногоон хөгжлийн сайд Санжаасүрэнгийн Оюуны удирдсан ИЗНН) авсан ба эдгээр намууд эвслийн засгийн газрыг бүрдүүлсэн. Монгол Ардын Нам (МАН) 26 суудал авч сөрөг хүчин болсон.² Өнгөрсөн удаагийн Ерөнхийлөгчийн сонгууль 2009 оны 5 дугаар сарын 24-ны өдөр явагдаж АН-аас нэр дэвшигч Цахиагийн Элбэгдорж 51.2 хувийн санал авч Ерөнхийлөгч асан Н. Энхбаярыг ялжээ.

Эрх зүйн орчин ба Сонгуулийн систем

Энэ удаагийн Ерөнхийлөгчийн сонгуулийн эрх зүйн орчин нь 1992 оны Үндсэн хууль (1999 болон 2001 онуудад нэмэлт өөрчлөлт орсон), Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль (2012 оны МУЕСТХ), Монгол Улсын Сонгуулийн төв байгууллагын тухай хууль (2006) болон шүүхийн тогтолцоог зохицуулах хуулиудаас бүрдэж байна. Сүүлийн үед шинэчлэгдсэн хууль тогтоомжийн өөрчлөлтүүд нь жендэрийн тэгш байдлын тухай дэвшилтэт хууль тогтоомж багтаж байна.³ Гэсэн хэдий ч эрх зүйн орчин нь цөөнх болон эмзэг бүлгийнхнийг үр дүнтэй

¹ Шударга ёс эвслийг Монгол Ардын Хувьсгалт Нам (МАХН) болон Монголын Үндэсний Ардчилсан Нам (МУАН) бүрдүүлдэг.

² Мөн гурван бие даан нэрээ дэвшүүлэгч Парламентад сонгогдсон. Одоогийн парламентийн 76 гишүүдийн арван нэг нь эмэгтэй гишүүд болно. (14 орчим хувь)

³ Жишээлбэл, Жендэрийн Үндэсний хорооны ивээл дор Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг 2011 онд, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх стратеги үйл ажиллагааны төлөвлөгөөг 2013 онд тус тус баталсан. Монголын улс төрд эмэгтэйчүүдийн төлөөлөл бага хэвээр байгаа ба Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулинд 2012 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр хувь тэнцүүлсэн төлөөллөөр сонгогдсон 28 суудалд жендэрийн 20 хувийн квотыг оруулсан.

хамгаалахгүй байна.⁴ Энэ удаагийн сонгууль нь шинэ МУЕСТХ-ийн дагуу явагдсан анхны сонгууль юм. Шинэ МУЕСТХ нь өмнөх хуулиасаа сайжирсан боловч орхигдсон асуудлууд, тодорхойгүй зүйл заалтууд, ялангуяа сонгуулийн сурталчилгааны зохицуулалттай холбоотой хязгаарлалтуудтай байна. СЕХ нарийвчилсан дүрэм журам гаргах эрх бүхий байгууллага ч, сонгуулийн хорооны гишүүдийг томилох шалгуур, эсвэл сонгуулийн санал авах өдөр гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам зэргийг гаргасангүй.

МУЕСТХ нь сонгууль эхлэхээс зургаахан сарын өмнө хүчин төгөлдөр болсон ба энэ нь олон улсын сайн туршлагатай уялдахгүй байна.⁵ ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-той уулзсан хүмүүс МУЕСТХ-ийг олон нийтээр хэлэлцүүлэлгүйгээр яаруу боловсруулж баталсан гэж мэдээлсэн бөгөөд бусад намын саналыг харгалзан авч үзээгүй хэмээн тэмдэглэж байв. Гэхдээ хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт УИХ-д суудалтай намууд болон СЕХ-ны төлөөлөл багтсан ба МУЕСТХ-д саналаа тусгуулжээ. ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-ны ажиглалтаар уг хуулийн дутагдалтай байдал нь хуулийг нэг мөр тайлбарлах болон хэрэглэхэд нөлөөлж байв. Хуулийг боловсруулж, баталсан байдал нь сонгуулийн үйл явцад итгэх итгэлийг бууруулсан нь ажиглагдаж байна.

Улс төрийн намуудыг улсын төсвөөс санхүүжүүлдэг бөгөөд МУЕСТХ-ийн дагуу зөвхөн улс төрийн нам болон нэр дэвшигчдийг санхүүжүүлэх эх сурвалжийг хандиваар бүрдүүлэхээр зохицуулжээ. СЕХ нам тус бүрийн сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг 5.1 тэрбум төгрөг (ойролцоогоор 2.7 сая евро), нэр дэвшигч тус бүрийн сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг 3.1 тэрбум төгрөг байхаар тогтоосон. Сонгуулийн сурталчилгаанд өгөх хандивын хэмжээг иргэн арван сая төгрөг, хуулийн этгээд тавин сая төгрөгөөс илүүгүй байхаар, зөвхөн сонгуулийн жилд хандив өгөхөөр тогтоожээ. Тодорхой эх сурвалжаас⁶ хандив авахыг уг хуулиар хориглосон. Энэхүү заалтыг зөрчвөл бага хэмжээний торгууль оногдуулна. СЕХ-ноос тогтоосон хязгаараас давсан мөнгийг хураахаар зохицуулжээ. МУЕСТХ-иар хандивлагч иргэн, эсвэл хуулийн этгээдийн овог нэр, оршин суугаа газрын хаяг болон хандивын хэмжээг заасан тайланг гаргах, мөн СЕХ эдгээр тайланг хүлээн авах, хянах, санал хураалт дууссан өдрөөс хойш 45 хоногийн дотор дүнг нийтэд мэдээлэх зэрэг нарийвчилсан шаардлагуудыг зааж өгчээ.

Ерөнхийлөгчийг нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргах зарчмаар дөрвөн жилийн хугацаагаар сонгодог. Эрх зүйн чадамжгүй гэдэг нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон, эсвэл хорих газар ял эдэлж байгаа иргэдээс бусад сонгуулийн санал авах өдөр 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэд сонгуульд саналаа өгөх эрхтэй.⁷ Ерөнхийлөгчид нэр дэвшигч анхны санал хураалтаар сонгогдохын тулд анхан шатны сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхи саналыг авах ёстой. Ингэж чадаагүй нөхцөлд хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийн хооронд хоёр дахь санал хураалтыг 14 хоногийн дотор явуулна. Хэрэв хоёр дахь санал хураалтаар Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн хэн нь ч ийнхүү

⁴ НҮБ-ын олон улсын гэрээний хэрэгжилтийг хангах хороод, Хүний эрхийн тогтмол дүгнэлтээс гарсан зөвлөмжүүдийг дараах холбоосоос харна уу.

<http://www.ohchr.org/EN/countries/AsiaRegion/Pages/MNIndex.aspx>

⁵ Олон улсын сайн туршлагаар сонгууль болохоос нэг жилээс доошгүй хугацаанд сонгуулийн хуулийн үндсэн элементүүдэд өөрчлөлт оруулах нь зохимжгүй гэж үздэг. Европын зөвлөлийн хуулиар ардчилал тогтоох Европын комисс (Венецийн комисс)-ын Сонгуулийн асуудлаарх сайн туршлагын дүрмийн II.2 b заалт [http://www.venice.coe.int/webforms/documents/CDL-EL\(2002\)005-e.aspx](http://www.venice.coe.int/webforms/documents/CDL-EL(2002)005-e.aspx) -аас үзнэ үү.

⁶ Гадаад улс, гадаадын байгууллага, эсвэл гадаад улсын иргэн, төрийн эсвэл орон нутгийн эрх бүхий байгууллагууд, эсвэл эдгээрийн эзэмшлийн хуулийн этгээд, өр төлбөртэй хүмүүс, үйлдвэрчний эвлэл, шашны болон төрийн бус байгууллагууд үүнд орно.

⁷ Олон улсын стандартын дагуу “Гэмт хэрэгт холбогдсоны улмаас сонгох эрхийг нь түтгэлзүүлбэл оноосон ялын хугацаатай ижил хугацаанд түтгэлзүүлнэ”. НҮБ-ын Хүний Эрхийн Хорооноос 1996 онд гаргасан Иргэний ба Улс Төрийн Эрхийн тухай Олон Улсын Хэлэлцээр (ИУГОУХ)-ийн 25 дугаарын Ерөнхий тайлбарын 25-р зүйлийн 14-р хэсгийг үзнэ үү. Урьдчилан хориход байгаа иргэний хувьд энэ хязгаарлалт хамаарахгүй тул сонгох эрхтэйг нь ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ тодрууллаа.

олонхи санал аваагүй бол дахин сонгууль явуулна. Сонгуулийг хүчинтэйд тооцохын тулд сонгуулийн хэсгийн хороонд бүртгэлтэй сонгогчдын 50-иас багагүй хувь ирж саналаа өгөх ёстой. Ирц хүрээгүй тохиолдолд СЕХ тухайн ирц хүрээгүй сонгуулийн хэсгийн хороонд сонгуульд оролцох эрхтэй ч, санал өгөөгүй сонгогчдоос нэмэлт санал авах талаар шийдвэр гарган, тухайн шийдвэр гарснаас долоо хоногийн дотор нэмэлт санал хураалтыг зохион байгуулна. Нэмэлт санал хураалтаар авсан саналыг өмнөх саналын тоон дээр нэмэх ба эдгээрийн нэгдсэн дүнг эцсийн дүн болгон авч үзнэ. МУЕСТХ-иар анхны санал хураах өдрийн өмнөх өдөр болон нэмэлт санал хураахаас өмнө сонгуулийн сурталчилгаа хийхийг хориглосон. СЕХ-ны мэдээлж байгаагаар энэхүү шаардлага нь хоёр дахь санал хураалт явагдах нөхцөлд мөн ижил байна. Энэ нь сонгуулийн нөхцөлд үндсэн эрх чөлөөг хэтэрхий хязгаарлаж болзошгүй.

Сонгуулийн захиргаа

Ерөнхийлөгчийн сонгуулийг улсын хэмжээнд СЕХ, аймаг нийслэлийн 22 сонгуулийн хороо (АНСХ буюу 21 аймаг болон нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд), сум, дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 339 сум, дүүргийн сонгуулийн хороо (СДСХ), хэсэгт 1,896 сонгуулийн хэсгийн хороо (СХХ) гэсэн дөрвөн шатлалаар зохион байгуулж явуулна. СЕХ нь зургаан жилийн хугацаатай Улсын Их Хурлаас томилогдсон есөн гишүүнтэй. Одоогийн СЕХ-ны хоёр гишүүн нь эмэгтэй юм. АНСХ нь есөн гишүүнтэй (нийслэлд долоон гишүүн), харин СДСХ, СХХ тус бүр долоон гишүүнтэй бөгөөд эрэгтэй гишүүдээс илүү эмэгтэй гишүүдтэй байна. Бүх доод шатны сонгуулийн хороодыг хуульд заасан хугацааны дотор бүрдүүлсэн.

Бүх шатны сонгуулийн хороодын гишүүдийг төрийн албан хаагчдын дундаас сонгосон. Сонгуулийн хороодод Төрийн албан хаагчийг ямар шалгуураар сонгон ажиллуулах тухай хуулинд тодорхой тусгаагүй байна. Сонгуулийн хороодын бүрэлдэхүүний талаар бичгээр үйлдсэн дүрэм журам, заавар байхгүй байна. СЕХ энэ талаар ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-нд мэдээлэхдээ хэдийгээр бичгээр гаргасан зохицуулах журам байхгүй ч сонгуулийн хороонд ажиллуулахаар сонгон дэвшүүлэхдээ тухайн албан хаагчийн туршлага, ‘нэр хүнд’-ийг харгалздаг гэсэн. ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-ны урт хугацааны зарим ажиглагчид (УХА-ид) тайландаа сонгуулийн захиргааны бүх шатанд, үүний дотор удирдах албан тушаалуудад⁸ АН-тай холбоотой төрийн албан хаагчид томилогдсон тухай баттай мэдээллүүдийг дурдсан.

Бүх шатны сонгуулийн хороод сонгуулийн үйл ажиллагааны асуудлуудыг үр дүнтэй удирдсан бөгөөд ерөнхийдөө сонгуулийн оролцогч талуудын итгэлийг хүлээсэн. СЕХ оны эхнээс хойш 12 удаа хуралдсан. СЕХ-ноос зохион байгуулсан хоёр удаагийн хурлын зөвхөн нэгнийх нь тухай мэдээллийг ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ авч оролцох урилга авсан. СЕХ-ны үйл ажиллагаа нь байнга ил тод, нээлттэй байсангүй. СЕХ хурлын тухай зараа цахим хуудсан дээрээ тавиагүй төдийгүй хурлын тэмдэглэлүүдээ байрлуулаагүй. СЕХ гаргасан шийдвэрүүдээ цахим хуудасныхаа “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт байрлуулдаг ба шийдвэрүүдийг огноогүйгээр зөвхөн дугаарладаг тул тусгай хуралтай холбогдож чаддаггүй.

СЕХ 40 гаруй дүрэм журам, заавар, албан ёсны сонгуулийн баримт бичгийн загварыг баталсан төдийгүй СЕХ-ны шийдвэрүүдээрээ товхимол гаргасан ба тэдгээр товхимолыг доод шатны сонгуулийн хороод сонгуулийн санал авах өдрөөс өмнө ба санал авах өдөр ашигласан. Гэхдээ доод шатны сонгуулийн хороодын ажилд зориулсан иж бүрэн дүрэм журмыг СЕХ батлаагүй. СЕХ нь сонгуулийг удирдан явуулах үүрэгтэй байгууллага хэдий ч сонгуулийн хууль тогтоомжийн тогтвортой, жигд хэрэгжилтийг хангахад шаардлагатай алхмуудыг байнга авч

⁸ ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ тайландаа Баян-Өлгий, Дорнод, Дундговь, Говь-Алтай, Хэнтий, Хөвсгөл, Өмнөговь, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Увс, Завхан аймгууд болон нийслэл Улаанбаатар хотын төсөөллийг тусгасан.

хэрэгжүүлээгүй. Үүнээс болж сонгуулийн урьдчилсан дүнг гаргах, санал авах байруудад суурилагдсан дүрс бичлэгийн аппаратууд дээрх дүрс бичлэгийг өргөдөл гомдол гаргах үйл явцад ашиглаж болох эсэх зэрэг сонгуулийн санал авах өдөр болон дараа нь гарч болох маргааны нөхцөл үйсч байгаа юм.

СЕХ АНСХ-дийн дарга нарт сургалт явуулсан бөгөөд энэхүү хүмүүс нь холбогдох доод шатны хороодын гишүүдэд адилхан сургалт явуулсан байна. Энэхүү сургалт нь ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-ны УХА-даас эерэг үнэлгээ авсан билээ. Түүнчлэн СЕХ сонгогчдын боловсролын хөтөлбөр хэрэгжүүлсэн бөгөөд уг хөтөлбөрийн хүрээнд сонгуульд санал өгөхийг уриалсан урилгыг сонгогч хэрхэн санал өгөх, зөврийн битүүмжилсэн хайрцагаар санал өгөх талаар зааварчилсан хэвлэмэл хуудсын хамт хэвлүүлэн айл өрх бүрт тараасан ба санал өгөх талаар үндсэн мэдээлэл бүхий хоёр видео клипийг телевизүүдээр цацсан. Сонгогчдод зориулсан мэдээлэл болон саналын хуудсыг зөвхөн монгол хэл дээр хэвлэсэн ба бичиг үсэг тайлагдаагүй эсвэл монгол хэлээр уншиж чадахгүй хүмүүст зориулан нэр дэвшигчдийн зургийг саналын хуудсанд оруулсан. СЕХ мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгох эрхээ эдлэхэд туслах зорилгоор энэ ажлыг гүйцэтгэх ТББ-д санхүүжилт олгосон. МУЕСТХ-ийн дагуу сонгуулийн хорооны санал авах байруудыг тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж наад зах нь нэг тусгайлан тоногдсон санал өгөх бүхээг бэлдэх ёстой.

Сонгуулийн хорооны санал авах байр бүрт сонгогчийг танин баталгаажуулах хурууны хээ уншуулах машин, мөн Санал Тоолох Автомат Төхөөрөмж (СТАТ) байрлуулсан. СТАТ нь санал уншуулах мөн тоолох зориулалттай машин ба сонгуулийн үйл ажиллагаа өндөрлөсөн даруйд сонгуулийн үр дүнг нэгтгэсэн тайлан хэвлэж гарган улмаар СЕХ руу сонгуулийн дүнг шууд илгээдэг. СЕХ-ны мэдээлснээр СТАТ-ны боловсруулсан АНСХ-ны шатны нэгдсэн дүнг цаасан дээр хийгдсэн АНСХ-ны нэгтгэсэн мэдээтэй тулган шалгана. ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилсон САХ-той уулзсан зарим хүмүүс, тэр дундаа улс төрийн намтай холбоотой хүмүүс, СТАТ⁹-ыг найдвартай эсэхт эргэлзэж байгаагаа илэрхийлсэн. СЕХ гадаадад байгаа сонгогчдод зориулан 6,494 саналын хуудас, Монгол Улсад байгаа сонгогчдод зориулан 1,893,207 саналын хуудсыг хуульд заасан хугацаанд хэвлүүлсэн.

Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газраас санаачилсан сонгуульд идэвхтэй оролцож саналаа өгсөн сонгогч бүрт 1000 төгрөг (0.50 орчим евро)¹⁰-ийн гар утасны нэгжээр урамшуулал олгох санаачлагыг СЕХ 6-р сарын 13-ны өдөр албан ёсоор дэмжив. Энэ үйлдэл нь МУЕСТХ-ийн хэд хэдэн зүйлийг¹¹ зөрчсөн байх талтай.

Сонгогчийн бүртгэл

Монгол Улсын сонгогчийн бүртгэл нь идэвхгүй, мөчлөгт бөгөөд Иргэний бүртгэл, мэдээллийн улсын сангийн мэдээлэлд үндэслэгддэг. Иргэний бүртгэлийг хөтлөн явуулдаг Улсын бүртгэлийн ерөнхий газар (УБЕГ) нь сонгууль бүрийн өмнө сонгогчийн цахим бүртгэлийг бэлтгэдэг. МУЕСТХ-д заасны дагуу сонгогчийн цахим бүртгэлийг олон нийтэд зориулан УБЕГ-ийн цахим

⁹ Сонгуулийн сурталчилгааны орчин гэсэн хэсгийг үзнэ үү.

¹⁰ Холбогдох зардлыг үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчид хариуцана. <http://gec.gov.mn/details/793> -аас үзнэ үү.

¹¹ МУЕСТХ-ийн 5.4-т заасны дагуу “Сонгогч сонгуульд оролцох эсэхээ бие даан шийдвэрлэх, саналаа чөлөөтэй илэрхийлэхэд нь албадан нөлөөлж, саад учруулах [аливаа].оролдлогыг хориглоно”. Энэ хуулийн 5.5-т “Сонгогч хөндлөнгийн нөлөөгүйгээр хүсэл зоригоо илэрхийлж, саналаа нууцаар гаргах боломжоор хангагдсан байна” гэж заасан. Түүнчлэн энэ хуулийн 43.8-т “Сонгууль зохион байгуулах хугацаанд гадаад, дотоодын тусламжийн эд хөрөнгийг иргэдэд тараах, худалдан борлуулж сонгуульд зарцуулахыг хориглоно” гэж заасан.

хуудсанд 3 сарын 1-ний өдөр байрлуулсан. Сонгогчдын нэрийн урьдчилсан жагсаалтыг сонгогчийн цахим бүртгэлд үндэслэн гаргаж хуульд заасан хугацааны дагуу 6 дугаар сарын 6-ны өдөр СХХ-дод хүргүүлсэн.

СХХ-дууд санал өгөх урилгыг сонгогчид цаг хугацаанд нь хүргэсэн. Сонгогчдыг бүртгэлээ хийн, мэдээллээ шалгахыг уриалсан сонгогчдын боловсролын хөтөлбөрийг УБЕГ бэлтгэн 6 дугаар сарын 6-наас 16-ны өдрүүдэд зурагт, радиогоор нэвтрүүлсэн. Түүнчлэн үүнтэй ижил мэдээллийг агуулсан сурталчилгааны хуудсыг сонингоор дамжуулан тараасан. Сонгогчид 6 дугаар сарын 6-наас 16-ны хооронд¹² бүртгэлээ хийх, засвар оруулах хүсэлт гаргах эсвэл сонгуулийн санал өгөх өөр хороонд шилжих хүсэлтээ гаргах боломжоор хангагдсан. Энэхүү боломж 6 дугаар сарын 16-наар дуусгавар болгож байгааг САХ-ныхонтой уулзаж ярилцсан зарим хүмүүс уян хатан бус, сонгуулийн санал өгөх өдрийг дөхүүлэн сонгогчийн бүртгэл эсхүл бүртгэлээ зөв болгох боломжийг хязгаарласан хэмээн үзэж байв.

ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-ны УХА-дын мэдээлсэнээр тэднийг 6 сарын 6-наас 16-ны хооронд СХХ-доор ажиглалт хийхэд сонгогчдын нэрсийн жагсаалтыг олон СХХ-дын байруудад нийтэд ил байхаар тавиагүй байжээ. Гэхдээ өөрийн бүртгэлийг шалгахыг хүссэн сонгогчдод СХХ-д жагсаалтыг үзүүлэх боломж нээлттэй байлаа. СХХ-дын гишүүд айл өрх нэг бүрээр орж нягтлах болон сонгогчийн урилгыг хүргэх ажилд оролцоноос болж энэхүү хугацаанд сонгогчдын жагсаалт огт байхгүй буюу хүртээмжгүй байх тохиолдлуудыг САХ тайландаа бас тусгасан. Сонгуулийн санал авах өдөр хүртэл цөөн хоног үлдээд байхад үйл ажиллагаагаа эхлээгүй байсан СХХ-д ч мөн байлаа. Үүнээс үүдэн сонгогчид бүртгэлээ баталгаажуулах, засвар оруулах боломжоор хангагдах 10-өдрийн үйл ажиллагааны хугацааг бууруулсан. 6 дугаар сарын 25-ны өдөр зөврийн саналын хайрцагаар санал өгсөн сонгогчдын нэрийн тусгай жагсаалтыг мөн гаргаасан. Бүртгэгдсэн сонгогчидын тоо 1,856,190 байлаа.¹³

Уулзаж ярилцсан улс төрийн намуудын төлөөлөл сонгогчийн бүртгэлийн систем болон сонгогчийн нэрсийн жагсаалтын чанарт ерөнхийдээ итгэлтэй байгаагаа илэрхийлж байхад ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-тай ярилцсан бусад хүмүүс орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал болон УБЕГ-ын хоорондын зохицуулалт муу, хаягжилтын нэгдсэн жишиг стандарт байхгүй түүнчлэн зарим хаяг дээр сонгогчид олноороо бүртгүүлсэн тохиолдлуудыг тэмдэглэсэн.

МУЕСТХ-иар гадаад улсад оршин суугаа иргэдийн санал өгөх бололцоог хангасан. Саналаа гадаадад өгөх хүсэлтээ гаргасан нийт 6,494 сонгогчийн 6,233 нь хуульд заасан хугацаанд буюу 5 дугаар сарын 29-ны дотор бүртгүүлсэн.¹⁴ Үүнээс 4,248 сонгогч гадаадын дипломат төлөөлөгчийн газруудад байгуулсан 39 санал өгөх байруудад 6 дугаар сарын 14-16-ны өдрүүдэл саналаа өгчээ.

Нэр дэвшигчийн бүртгэл

Ерөнхийлөгчид нэр дэвшигч нь сонгууль өгөх эрх бүхий, дөчин таван нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, эцэг эх хоёул Монгол Улсын харъяат болохыг баталж чадах Монгол улсын уугуул иргэн байх ёстой. Эдгээр нөхцөлүүд нь хэт

¹² Нийт 40,715 сонгогч энэхүү боломжийг ашигласан

¹³ УБЕГ-ын цахим хуудсыг үзнэ үү. <http://www.burtgel.mn>

¹⁴ МУЕСТХ-д зааснаар 60 хоног эсвэл түүнээс илүү хоногоор гадаадад байх сонгогчийг сонгогчдын нэрсийн жагсаалтаас түр хасах ба Монголдоо буцаж ирсэн сонгогчдийн хувьд 6 сарын 16-наас хэтрэхгүйгээр дахин бүртгэл хийлгэх шаардлагатай. СЕХ-ны мэдээллэж байгаагаар түр хугацаагаар гадаадад байгаа иргэд гадаад оронд байгаа санал авах байранд бүртгүүлж, саналаа өгөх боломжтой. УБЕГ-ын мэдээллээр 261 сонгогчийн хүсэлтийг цахим үнэмлэхгүй, хуулиар шаардсан баримт бичгийн бүрдэл дутуу, эсвэл иргэний бүртгэлт байгаа нэр болон иргэний үнэмлэхийн дугаар тохирохгүй байна гэсэн үндэслэлээр татгалзжээ

хязгаарласан шинж чанартай байгаа бөгөөд ЕАБХАБ-ын итгэл үнэмшил болон олон улсын бусад стандартуудтай нийцэхгүй байна.¹⁵ Үндсэн хууль болон МУЕСТХ-ийн дагуу зөвхөн УИХ-д суудалтай улс төрийн нам, эвслээс ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх эрхтэй.¹⁶ 1990 оны ЕАБХАБ-ын Копенгагены баримт бичгийн 7.5-р зүйл заалтаас ялгаатай нь ерөнхийлөгчийн сонгуульд хувь хүн бие даан нэр дэвших боломжгүй юм.

Энэ удаагийн сонгуульд нэр дэвшигч өрсөлдөж АН-аас одоогийн Ерөнхийлөгч Ц. Элбэгдорж, МАН-аас УИХ-ын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ, мөн Монгол Улсын түүхэн дэх анхны эмэгтэй нэр дэвшигч болох МАХН-аас Эрүүл Мэндийн сайд Н. Удвал тус тус нэр дэвшив. Гурван нэр дэвшигч МУЕСТХ-д заасан хугацаанд СЕХ-д бүртгүүлсэн.

Сонгуулийн сурталчилгааны орчин

Сонгуулийн сурталчилгааны орчин эвлэлдэн нэгдэх, цуглаан, хөдөлгөөний хийх үндсэн эрх чөлөөнд хүндэтгэлтэй хандсан байдалтай байлаа. Өрсөлдөгчид сонгуулийн сурталчилгаагаа саад тотгоргүй явуулсан бөгөөд тэдний зохион байгуулсан цуглааны үеэр ямар нэг осол зөрчил гараагүй болно. Сонгуулийн сурталчилгааны эхний үеийг тайван үйл ажиллагаа, одоогийн Ерөнхийлөгчийг сурталчилгаагаа эрт эхлүүлсэн¹⁷ тухай гомдол болон СТАТ-ыг ашиглахтай холбоотой асуудлуудаар онцолж болно. Харин сонгуулийн сурталчилгааны төгсгөл үед сонгуулийн сурталчилгаа нэлээд ил харагдахуйц, өрсөлдөөн үндсэндээ одоогийн Ерөнхийлөгч болон Б. Бат-Эрдэнэ нарын хооронд явагдаж байсан ба заримдаа үндсэрхэг¹⁸ өнгө аястай мэдэгдэл, улс төрийн туйлшрал ажиглагдаж байлаа. Сурталчилгаа идэвхжсэн хэдий ч нэр дэвшигчид эсвэл тэдний төлөөлөгчдийн хооронд мэтгэлзээн бараг өрнөсөнгүй. 6 сарын 24-ны өдөр Үндэсний Олон нийтийн Радио Телевизээр нэр дэвшигчдийн дунд ганцхан удаа халз мэтгэлцээн зохион байгуулагдсан ба халз мэтгэлцээний хэлбэр, зохион байгуулалтыг

¹⁵ Нэр дэвшигчийн эцэг эх хоёул Монгол Улсын иргэн байна гэсэн шаардлага нь ЕАБХАБ-ын 1990 оны Копенгагены баримт бичгийн 7.3 дахь хэсэгт заасан сонгуулийн эрхийн нийтлэг шалгуурт нийцээгүй ба хязгаарлалт ихтэй байна. Уг баримт бичиг нь ЕАБХАБ-ын гишүүн орнууд “насанд хүрсэн иргэн бүрт нийтлэг, тэгш сонгуулийн эрх” баталгаажуулахыг даалгасан байдаг. Ерөнхий Тайлбарын 25-ын 15 дугаар хэсэгт сонгуульд оролцох эрхийг оршин суух газар, гарал үүслээр шалтгаалан хязгаарлах нь үндэслэлгүй, ялгаварлан гадуурхсан заалт болохыг тодорхойлжээ. Энэхүү заалт нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын конвенцид заасан үндэс яс, нийгмийн гарал, гарал үүсэл болон бусад байдлыг ялгаварлан гадуурхахыг хориглосон 2-р зүйлтэй бас зөрчилдөж байна.

¹⁶ Сонгуулийн үйл явцад орох боломж, нэр дэвшүүлэх эрхийн хязгаарлалт нь сонгогчдын сонголтонд хязгаарлалт болж байна хэмээн үзэж байгаа үүнд сэтгэл ханамжгүй байгаа тухайгаа зарим нэг жижиг улс төрийн намууд ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-д дуулгасан.

¹⁷ ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-ныхны уулзаж ярилцсан зарим хүмүүс одоогийн Ерөнхийлөгчийг сонгуулийн сурталчилгаа албан ёсоор эхлэхээс өмнө сурталчилгааныхаа ажлыг эхлүүлсэн хэмээн гомдоллож байсан. 5 дугаар сарын 17-20-ны хооронд урт хэмжээний ярилцлагыг үзэгчдийн оргил цагаар янз бүрийн зурагтын сувгаар өгсөн хэмээжээ. Үүнээс болж МАН сонгуулийн сурталчилгаагаа хугацаанаас өмнө эхлүүлсэн хэмээн үзэж Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар (ШӨХТГ) болон цагдаад гомдол гаргасан бөгөөд тэрхүү гомдлыг ШӨХТГ одоогийн Ерөнхийлөгчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрөөс нэвтрүүлгийн ярилцлагад яригдаагүй байна гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон бол цагдаагийн байгууллагад өгсөн гомдол шийдэгдээгүй хүлээгдэж байна.

¹⁸ 6 дугаар сарын 11-нд Дорнод аймагт болсон Б. Бат-Эрдэнийн сонгуулийн сурталчилгааны цуглааны үеэр түүний төлөөлөгчид өөрийн нэр дэвшигчээ Хэнтий аймагт төрсөн болохоор бусад нэр дэвшигчдээс давуу гээд “жинхэнэ” Монгол хүмүүс Завхан, Говь-Алтай, Ховд аймгуудад бус төвийн аймгуудад амьдардаг хэмээн онцолжээ. Энэ талаар 6 дугаар сарын 12-ны Өдрийн сонин дээр нийтэлжээ. Баруун аймгийнхан, ялангуяа Увчууд энэхүү мэдээллийн эсрэг эсэргүүцлээ илэрхийлжээ. ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-ны УХА-чидын ажиглалтаар Н. Удвал харийнханд эх орноо худалдах асуудлыг эцэс болгох мөн гадаадын хөрөнгө оруулалтыг бууруулна хэмээн 5 дугаар сарын 23, 6 дугаар сарын 3-ны өдрүүдэд Хэнтий аймгийн Өндөрхаан, 6 сарын 2-ны Дорнод аймгийн Чойбалсан, 6 сарын 13-нд Говьсүмбэрийн Чойр болон 6 сарын 18-нд Баян-Өлгий аймгийн Өлгий сумдуудад хийсэн сурталчилгааны үеэр амлажээ.

сонгуулийн сурталчилгааны багуудаар урьдчилан тодорхойлуулсан нь тодорхой сэдвүүдийг¹⁹ хөндөх болон цаг хугацааны хувьд хязгаарлагдсан, хэлэлцүүлэг өрнөх боломж багатай болсон.

Өнөөгийн Ерөнхийлөгч Ц. Элбэгдорж болон АН-ын төлөөлөгчидийн зүгээс СТАТ-ийг ашиглах ач холбогдлыг “шударга ёсыг дээдлэх ашиг сонирхолд нийцнэ”²⁰ гэж удаа дараа онцолж байсан бол, МАН-аас нэр дэвшигч Б. Бат-Эрдэнэ болон МАХН-аас нэр дэвшигч Н.Удвал нар СТАТ-ны талаар СЕХ-ноос сонгогчдод зориулан гаргасан мэдээлэл хангалтгүй гэж үзэхийн зэрэгцээ автоматаар болон гараар тоолсон дүн нийцэхгүй тохиолдолд СЕХ-ноос үүнийг зохицуулах зохицуулалтгүй байна гэж онцолж байлаа. 6 дугаар сарын 5-ны өдөр нэр дэвшигч Б. Бат-Эрдэнэ автоматаар санал тоолох үйл явц нь ил тод биш, сонгогчид үл итгэдэг гэх үндэслэлээр хүн ам ихээр төвлөрсөн аймаг, хотуудад²¹ саналын хуудсыг гараар тоолох саналд нэгдэхийг нөгөө хоёр нэр дэвшигчиддээ хандан уриалсан. Үүний хариуд СЕХ нь 6 дугаар сарын 6-ны өдөр МАН-д албан бичгээр МАН-ын нэр дэвшигч МУЕСТХ-ийг зөрчихийг уриалахгүй байхыг шаардав. Түүнчлэн ШӨХТГ²² нь АН-аас ирүүлсэн гомдлын дагуу шалгалт хийн нэр дэвшигч Б. Бат-Эрдэнийн уриалгыг МУЕСТХ-ийн 33.7.7 дахь заалтыг зөрчсөн гэж үзэн түүнд анхааруулга өгсөн. МАН гараар тоолохын төлөөх ухуулгаа үргэлжлүүлсэн. 6 дугаар сарын 19-ны Өнөөдөр сонин дээр ЦЕГ-аас МАН энэхүү үйлдэл нь олон нийтэд нөлөөлөн нийгмийн хэв журам алдагдуулж болзошгүй хэмээн анхааруулсан.

Сонгуулийн сурталчилгааны тэгш боломжийг хангах зорилготой хязгаарлалтуудыг шинэ МУЕСТХ-иар тогтоосон. Тухайлбал бэлэн мөнгө тараах, Ерөнхийлөгчийн гүйцэтгэх бүрэн эрхэд²³ хамааралгүй аливаа төрлийн санхүүгийн эсвэл ажлын байрны амлалт өгөхийг хориглосон. ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-ны УХА-дын ажигласнаар гурван нэр дэвшигч гурвуулаа МУЕСТХ-ийг зөрчин санхүүгийн чанартай²⁴ амлалтууд өгсөн тохиолдол гарсан. Үүнтэй холбоотойгоор МАН болон АН-ын аль аль нь гомдол гаргасан.²⁵ Нэр

¹⁹ Эдгээр сэдвүүдэд нэр дэвшигчдийн ирээдүйн тэргүүлэн авч үзэх ерөнхий асуудлууд, эдийн засгийн хөгжил, шүүхийн бие даасан, хараат бус байдал, батлан хамгаалах бодлого, уул уурхай, үндэсний өв соёл, боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, газар тариалан, үндэсний аюулгүй байдал, төвлөрөлийг сааруулах болон авлигын асуудлууд багтана.

²⁰ <http://cdmongolia.mn/statements/>-аас үзнэ үү.

²¹ Улаанбаатар хот, Дархан –Уул, Орхон, Хөвсгөл аймгууд.

²² СЕХ/ХХЗХ хамтарсан тогтоолын дагуу “Радио, телевизээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх” журмыг ШӨХТГ хянана. Хяналт тавих техник хэрэгсэл, арга зүй дутмаг байдлаасаа болж ШӨХТГ тоон болон чанарын хяналт хийж чадахгүй зөвхөн өргөдөл гомдол ирсэн тохиолдолд хариу үйлдэл хийдэг. Холбогдох хуулийн заалтуудыг зөрчсөн тохиолдолд хэвлэл мэдээллийн хэрэгслийн тусгай зөвшөөрлийг гурав хүртэлх сарын хугацаагаар ХХЗХ-ноос түтгэлзүүлнэ.

²³ Нэр дэвшигчид ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хүрэн дэх чиглэлүүдээс зөвхөн шүүх эрх мэдлийн шинэтгэл, гадаад харилцаа гэсэн хоёр чиглэлийг онцолсон. Бусад нь ерөнхийдөө бэлэгдлийн чанартай болно.

²⁴ Ийм амлалтуудыг Ц. Элбэгдорж 5 дугаар сарын 22-ны өдөр Чойбалсан (Дорнод аймаг), 6 дугаар сарын 4-ны өдөр Алтай (Говь-Алтай аймаг), 6 дугаар сарын 6-ны өдөр Өлгий (Баян-Өлгий аймаг), 6 дугаар сарын 9-ны өдөр Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэг, 6 дугаар сарын 11-ны өдөр Зуунмод (Төв аймаг), 6 дугаар сарын 16-ны өдөр Сайхан сум (Сэлэнгэ аймаг)-д ажиллахдаа өгсөн. Дэлгэрэнгүйг ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-ны Урьдчилсан Тайлан Дугаар 01-ээс үзнэ үү. Б. Бат-Эрдэнэ дунд сургууль, цэцэрлэг барих түүнчлэн залуучуудыг хямд үнэтэй орон сууцаар хангах (Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг, 6 дугаар сарын 8-ны өдөр), оюутнуудад сар бүр 70,000 төгрөгийн тэтгэлэг олгох хөтөлбөрийг үргэлжлүүлэх (6 дугаар сарын 10-ны өдөр Сэлэнгэ аймаг Сүхбаатар, 6 дугаар сарын 19-ны өдөр Өмнөговь аймаг Даланзадгад) тухай амлав. Үүнээс гадна тэрээр 6 дугаар сарын 10-ны Дархан-Уул аймагт ажиллах үеэрээ Монгол Улсын иргэн бүрт олгох *Оюу Толгой* компанийн 1,072 ширхэг хувьцаантай холбоотой амлалтуудыг өгсөн. Н. Удвал бас оюутнуудад тэтгэлэг олгох амлалт өгсөн ба уул уурхайн орлогоос гэхээс илүүтэйгээр татвар төлөгчдийн мөнгөөр тэдэнд тэтгэлэг олгоно гэв (6 дугаар сарын 18-ны өдөр Баян-Өлгий аймаг, Өлгий).

²⁵ МАН гомдлоо 5 дугаар сарын 25-ны өдөр Нийслэлийн Цагдаагийн газарт гаргав. (ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-ны Урьдчилсан Тайлан Дугаар 02-оос үзнэ үү) АН нэр дэвшигч Б. Бат-Эрдэнийн хэд хэдэн ТВ-ийн сувгаар улс төрийн сурталчилгааны хэлбэрээр гаргасан оюутны тэтгэлэгийг үргэлжлүүлнэ гэсэн амлалттай холбоотой гомдлыг СЕХ-нд гаргав (хувийг ШӨХТГ хүргүүлэв)

дэвшигчдийн сонгуулийн сурталчилгааны амлалтуудын дийлэнх хэсэг нь²⁶ давхцаж байсан учир нэр дэвшигч бүр өрсөлдөгчдөөсөө ялгарах тодорхой чиглэлийг онцолцгоосон ба энэ нь тэдний дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийг нэлээд ялгаатай болгож өгсөн хүргэсэн. Бүх нэр дэвшигчид нийслэл, дүүрэг, аймгийн түвшинд сонгуулийн сурталчилгааа хийж байхад тэдний төлөөлөгчид болон сонгуулийн сурталчилгаанд оролцогчид хөдөө орон нутагт сурталчилгааны ажил явууллаа.

ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-ны УХА-чид гурван нэр дэвшигчийн орон даяар явуулсан 56 сонгуулийн сурталчилгааны үйл ажиллагааг ажиглалаа. ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-ны УХА-дын ажигласнаар цуглаанд оролцогсдын 54 орчим хувь нь эмэгтэйчүүд байлаа. Цуглааныг гадаа болон дотор хийж байсан бөгөөд зах, төв гудамжинд сонгогчидтой уулзахдаа багахан хэмжээний уулзалт хэлбэрээр хийж байлаа. МАН болон АН-ын хувьд сонгуулийн сурталчилгааныхаа нугалбар, нам/нэр дэвшигчийнхээ тухай сонинг тараахдаа олон тооны албан байрыг ашигласан ба үүнд сурталчилгааны гэрүүд багтана. Мөн түүнчлэн намын ухуулагчид айл өрх дамжин ухуулга сурталчилгаа хийж байлаа. Сонгуулийн сурталчилгааны сүүлийн долоо хоногт²⁷ сурталчилгааны самбар, өлгөмөл зурагнуудын тоо нэмэгдсэн. Сонгуулийн санал авах өдөр ойртох тусам гурван нэр дэвшигчийн зурагт хуудас, намынх нь туг СХХ-ны ойр хавьд түүнчлэн хувийн байшин болон гэрүүд дээр элбэг үзэгдэж байв. Нэр дэвшигчид болон тэдний төлөөлөгчид цахим мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээ (social network), тухайлбал Фэйсбүүк, Твиттерийг идэвхтэй ашиглахаас гадна гар утас руу сонгуулийн сурталчилгааныхаа мессежийг илгээж байсан.²⁸

Хэвлэл мэдээлэл

Эрх зүйн орчин үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хангадаг. Гэсэн хэдий ч гүтгэн доромжилсон хэргээр эрүү үүсгэдэг нь гол дутагтал тал бөгөөд гүтгэн доромжилсон хэргээр хорих ял авах боломжтой ба сэтгүүлчдийн эсрэг (цалингийн доод хэмжээг 60 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэлх хохирол) үүсгэсэн эрүүгийн хэргийн тоо өссөнөөр хувийн цензур²⁹ нэмэгдэж байна. Цаашлаад интернэт ашиглагчийн санал сэтгэгдлийн агуулгыг филтердэх асуудлыг Засгийн газрын 2013 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн тогтоолоор зохицуулах болсон ба уг тогтоол нь хэвлэл мэдээллийн тухай олон улсын стандартыг зөрчих “гүжирдлэг, доромжлол, хараал зүхэл болон айлган сүрдүүлэлт”-ийн эсрэг тэмцэх зорилготой.³⁰

Хэвлэл мэдээллийн зах зээл улс төрийн олон ургалч үзлийг тодорхой түвшинд зөвшөөрдөг ба энэ байдлаас болж маш олон тооны хэвлэл мэдээллийн хэрэгслүүд улс төрийн оролцогчдын

²⁶ Бүх нэр дэвшигчид мөрийн хөтөлбөртөө авлига, ажилгүйдэл, уул уурхайгаас үүдэлтэйгээр нийгэм, байгаль орчин, эдийн засаг, засаглалд үзүүлж буй сөрөг нөлөө, болон архидалтай тэмцэх, түүнчлэн шүүх эрх мэдлийг шинэчлэх, нийтийн албыг улс төрөөс ангид байлгах, амжиргааны түвшинг сайжруулах, сургууль, эмнэлэгт оруулах хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, ОХУ болон БНХАУ-тай сайн харилцааг эрхэмлэх гадаад бодлогыг үргэлжлүүлнэ гэж амласан.

²⁷ ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ хоёр хэл (Монгол-Казак) дээр бичигдсэн сурталчилгааны самбар, зурагт хуудас байхыг Баян-Өлгий аймаг ажиллахдаа анзаарав .

²⁸ Сонгуулийн сурталчилгааны сүүлчийн өдөр Б. Бат-Эрдэнэ залуучуудад хандан урьдчилгаа төлбөргүйгээр хямд үнэтэй орон сууцны зээлд хамруулах, түүнчлэн амжилттай суралцаж байгаа оюутнуудыг түр хугацаагаар дэмжих тухай мессежийг илгээсэн.

²⁹ Гүтгэх гэмт хэргийг эрүүгийн хуулиас халах тухай өөрчлөлт оруулах Эрүүгийн хуулийн төслийг 2013 онд УИХ-аар хэлэлцэх байх

³⁰ ЕАБХАБ-ын Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний төлөөлөгчийн НҮБ, Америкийн Улсуудын байгууллага (АУБ), Хүний ба Улс Түмний Эрхийн Төлөөх Африкийн Комисс (АК)-ын Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх тухай тусгай илтгэл-тэй хамтран гаргасан тунхаглалыг <http://www.osce.org/fom/78309>-аас үзнэ үү. Энэхүү хамтарсан тунхаглалд “Засгийн газар эсхүл арилжааны үйлчилгээ үзүүлэгчийн хариуцдаг, эцсийн хэрэглэгчээр үл хянуулдаг агуулга филтердэх систем нь цензүүрийн өмнөх хэлбэр бөгөөд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх явдалд хязгаар тавидаггүй” хэмээн заажээ.

шууд болон шууд бус эзэмшилд байдаг бөгөөд мэдээний хөтөлбөрийн агуулгад эзэмшигч хөндлөнгөөс нөлөөлдөг. Түүнчлэн хэвлэл мэдээллийн эзэмшилд ил тод байдал дутмаг ба үүнийг хуулиар зохицуулаагүй байна.³¹ Мэдээний хөтөлбөрийн агуулгад эзэмшигчээр дамжуулан эсвэл төлбөр төлөх замаар нөлөөлөх байдал түгээмэл болохыг сэтгүүлчид ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-нд мэдээлсэн. Түүнчлэн тэд улс төрийн өрсөлдөгчдөө гүтгэн доромжилсон “Хар ПР”-ийг гаргах тал дээр хэвлэл мэдээллийн эзэмшигчдийн нөлөө байдгыг хэлсэн.³² Редакцийн бие даасан хараат бус байдал ихээхэн дутагдалтай байгаагаас эрэн сурвалжлах сэтгүүл зүй болон хэвлэл мэдээллийн ардчилсан чиг үүрэг үндсэндээ нуран унадаг бөгөөд эзэмшигчийн ил тод бус байдал нь олон нийт хэвлэл мэдээллээр цацагдаж байгаа мэдээллийг үнэлэж цэгнэх боломжоор хязгаарлагддаг.³³

МУЕСТХ-ийн заалтууд, СЕХ-ноос гаргасан нэмэлт шийдвэрийн дагуу цахим хэвлэлийн тусгай зөвшөөрлийг Засгийн газрын агентлаг болох Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ) олгодог ба 2013 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр

Хуульд заасны дагуу МҮОНТ нь нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгааг СЕХ-ны бэлтгэж өгсөн хуваарийн дагуу үнэ төлбөргүй нэвтрүүлэх үүрэгтэй, харин арилжааны телевизүүд ижил хэмжээтэй төлбөртэй цагийг нэг өдөрт нийт нэг цаг байхаар нэр дэвшигчдэд гаргаж өгдөг. Мэдээний хөтөлбөрөөр сонгуулийн сурталчилгааг явуулж болох эсэхийг тодорхой зохицуулаагүй байна.³⁴ Хуулийн заалтыг дагаж мөрдөхийн тулд хэвлэл мэдээлэл бүх нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгааг мэдээний хөтөлбөртөө адил хэмжээтэйгээр оруулах, мөн улс төрийн сурталчилгааг нь тэнцүү хэмжээтэйгээр нэвтрүүлнэ гэж ЕАБХАБ-ын АИХЭГ-ын САХ-нд мэдээлсэн.

МУЕСТХ-иар гүтгэх, улс төрийн оролцогчид худал мэдээлэл тараах асуудлыг маш тодорхой хориглосон. Хэвлэл мэдээллээр хууль бус мэдэгдэл, үүнийн дотор төрийн сурталчилгааг тараасан тохиолдолд хариуцлага хүлээлгэнэ.³⁵ ШӨХТГ хэд хэдэн хэвлэл мэдээлэлтэй холбоотой өргөдөл гомдол хүлээн авч шийдвэрлэсэн бөгөөд нэг тохиолдлыг дурдвал нэр дэвшигч Б.Бат-Эрдэнийн сонгуулийн сурталчилгааны урианы үгийг санаатайгаар үсэг өөрчлөн гуйвуулсан сэтгүүлчдэд торгууль ногдуулсан байна.

³¹ Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшлийн ил тод байдал, редакцын хараат бус байдлыг зохицуулах заалтыг тусгасан Хэвлэлийн Эрх Чөлөөний тухай хуулийн төслийг Ерөнхийлөгч УИХ-д өргөн барисан бөгөөд хоёр дахь уншилтын дараа Ерөнхийлөгч 2013 онд буцаан татсан болно.

³² Ийм туршлага нэлээд нийтлэг байдаг бөгөөд зөвхөн сонгуулийн үеэр ажилладаг телевизүүдээс болоод, өмнөх сонгуулийн сурталчилгааны үед ийм байдал нэмэгдсэн.

³³ ЕХ-ны Өндөр Түвшний Бүлгийн Хэвлэл мэдээллийн эрх чөлөө ба олон ургальч үзлийн тухай тайланг (“Европын ардчилалыг дэмжин хамгаалах чөлөөт, олон ургальч хэвлэл мэдээлэл”) <http://ec.europa.eu/digital-agenda/sites/digital-agenda/files/HLG%20Final%20Report.pdf> –аас үзнэ үү.

³⁴ Сонгуулийн сурталчилгааг мэдээний хөтөлбөрөөр явуулж болох эсэхийг тодруулахаар МҮОНТ-ийн бичгээр илгээсэн хүсэлтэнд СЕХ албан ёсоор хариулаагүй. Мэдээний хөтөлбөрөөр сонгуулийн сурталчилгаа явуулах нь хуулийн заалт зөрчсөн үйлдэл биш гэсэн хариултыг МҮОНТ амаар авсан тухай мэдээллийг ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ авсан. ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-ныхонд UBS арилжааны телевизийн мэдээлсэнээр “хуулиар мэдээний хөтөлбөрөөр нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааг явуулахыг хориглосноос” хойш тэд мэдээний хөтөлбөрөөр сонгуулийн сурталчилгаа явуулахаа болисон байна.

³⁵ ЕАБХАБ-ын Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний төлөөлөгчийн (ХМЭЧТ) НҮБ, Америкийн Улсуудын байгууллага (АУБ), Хүний ба Улс Түмний Эрхийн Төлөөх Африкийн Комисс (АК)-ын Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх тухай тусгай илтгэл-тэй хамтран гаргасан Хэвлэл мэдээлэл болон Сонгуулийн тухай хамтарсан мэдэгдлийг <http://www.osce.org/fom/37188>-аас үзнэ үү. Энэхүү хамтарсан мэдэгдэлд “нэвтрүүлсэн мэдээ мэдэгдлийг хууль бус болохыг нь шүүхээр тогтоосон эсвэл хүчирхийлэлд шууд турхирсан, болон хэвлэл мэдээллийн хэрэгслэл нь нэвтрүүлэг гаргахаас урьдчилан сэргийлснээс бусад нам эсвэл нэр дэвшигчээс шууд гаргаж байгаа хууль бус мэдээ мэдэгдэлд нөхцөл байдлаас үл хамааран хэвлэл мэдээлэл хариуцлага хүлээхгүй” хэмээн заажээ.

Хэвлэл мэдээллийн цахим хэрэгслүүд төлбөртэй ба төлбөргүй явуулах сонгуулийн сурталчилгааны мэдээлэл болон улс төрийн сурталчилгааг гурван нэр дэвшигчдэд ижил тэнцүү явуулах тухай сонгуулийн сурталчилгаатай холбоотой хуулийн заалтыг хэрэгжүүлж байсан нь ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-нд хэвлэлийн мониторингийн³⁶ үр дүнгээр батлагдлаа.³⁷ Харин сүүлийн үеийн үйл явдал болон мэдээний хөтөлбөрүүдээр сонгуулийн сурталчилгаа ихээхэн хязгаартай гаржээ.³⁸ МҮОНТ болон арилжааны TV9 телевиз нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгааг мэдээний цагаараа тэнцвэртэйгээр гаргасан байхад, арилжааны Йигл ТВ болон TV5 телевизүүд одоогийн Ерөнхийлөгч руу чиглэсэн өрөөсгөл мэдээллийг гаргасан байна.³⁹ Мониторинг хийсэн бүх телевизүүдээр хэлэлцүүлгийн нэвтрүүлэг тогтмол гарж байсан хэдий ч нэр дэвшигчдийн дунд зөвхөн ганцхан мэтгэлцээнийг 6 дугаар сарын 24-ны өдөр явуулсан. Сэтгүүлчид, шинжээчид болон олон нийт өөрсдийн сонирхсон асуултуудаа нэр дэвшигчдээс асуух, мөн түүнчлэн нэр дэвшигчид хоорондоо мэтгэлцэх боломж олгох нэвтрүүлгүүд бараг байсангүй. Энэ байдал нь хэвлэл мэдээллийнхэн өөрсдийн чиг үүргээ биелүүлэн сонгуулийн асуудлаар болон улс төрийн сонголтуудын талаар ул суурьтай, хүчтэй олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх боломж олгосонгүй төдийгүй сонгогчид мэдээллээр сайн хангагдах замаар шийдвэр гаргах үйл явцад хувь нэмэр оруулах, оролцох чадварт нь сөргөөр нөлөөлсөн.

Өргөдөл гомдол

МУЕСТХ нь шат дараалсан хариуцлага тооцох зарчмаар өргөдөл, гомдол шийдвэрлэх үйл ажиллагааны процессыг нарийн тодорхойлоогүй байгаагаас хууль зөрчсөн тохиолдолд энэ талаарх өргөдөл гомдлыг хэд хэдэн шүүх, төрийн тусгай байгууллагууд харьяаллаараа хянах, шийдвэрлэх эрхтэй. МУЕСТХ-иар нарийн зохицуулалтгүй ч СЕХ-ны гомдлыг барагдуулсан байдал асуудалтай байна хэмээн үзвэл СЕХ-ны шийдвэрийн талаарх гомдлыг Чингэлтэй дүүргийн шүүхэд, СЕХ-ны шийдвэр Үндсэн хуулийг зөрчсөн хэмээн үзвэл гомдлыг Үндсэн хуулийн цэцэд гаргах эрхтэй хэмээн СЕХ мэдээллээ. Харин Үндсэн хуулийн цэц нь зөвхөн СЕХ-ны бичгээр гаргасан шийдвэрийн талаарх гомдлыг хүлээж авдаг. МУЕСТХ-д зааснаар хууль зөрчсөн талаарх бусад бүх өргөдөл гомдлыг цагдаагийн байгууллага шалгах ба шалгалт дээр үндэслэн харьяа орон нутгийн шүүх шийдвэрлэнэ.

Хэд хэдэн байгууллага сонгуулийн маргааныг харьяалж, шийдвэр гаргах эрхтэй байгаа, эдгээр байгууллагуудын сонгуультай холбоотой хөндөгдсөн эрхийг сэргээх дээр эрх мэдлийнх нь хүрээг хуулиар нарийн зохицуулаагүй байгаа нь сонгуультай холбоотой хөндөгдсөн эрхийг

³⁶ ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-нд UBS-ийн мэдээлсэнээр бол телевизнэр дэвшигч Н. Удвалд санал тависан хэдий ч түүнтэй гэрээ байгуулаагүй болохоор хэдий улс төрийн төлбөртэй сурталчилгаа ч гэсэн тэрхүү сурталчилгааг гаргаагүй байна.

³⁷ МҮОНТ-ын хувьд сонгуулийн сурталчилгааны бүх хугацаанд 5 дугаар сарын 22-ноос 6 дугаар сарын 14-ны хооронд гурван нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгааг нийт 3 цаг 20 минутын хугацаанд явуулжээ. Арилжааны телевизүүд нэлээн бага хугацаагаар гаргасан байна. Йигл ТВ-1 цаг 46 минут, ТВ5-ойролцоогоор 1 цаг, ТВ9-36 минут, UBS-хуулиар мэдээний хөтөлбөрөөр сонгуулийн сурталчилгаа явуулахыг хориглосон гэж ойлгож байсан тул мэдээнийхээ хөтөлбөрөөр сонгуулийн сурталчилгаа явуулаагүй байна

³⁸ МҮОНТ-ын хувьд сонгуулийн сурталчилгааны бүх хугацаанд 5 дугаар сарын 22-ноос 6 дугаар сарын 14-ны хооронд гурван нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгааг нийт 3 цаг 20 минутын хугацаанд явуулжээ. Арилжааны телевизүүд нэлээн бага хугацаагаар гаргасан байна. Йигл ТВ-1 цаг 46 минут, ТВ5-ойролцоогоор 1 цаг, ТВ9-36 минут, UBS-хуулиар мэдээний хөтөлбөрөөр сонгуулийн сурталчилгаа явуулахыг хориглосон гэж ойлгож байсан тул мэдээнийхээ хөтөлбөрөөр сонгуулийн сурталчилгаа явуулаагүй байна.

³⁹ МҮОНТ мэдээнийхээ 31 хувийг Б: Бат-Эрдэнэд, 36 хувийг Ц. Элбэгдоржид, 33 хувийг Н.Удвалд зориулсан байна. ТВ9-ийн хувьд 32 хувийг Б: Бат-Эрдэнэ, Ц. Элбэгдоржид нарт, 36 хувийг Н.Удвалд өгсөн байна. Йигл ТВ-ийн хувьд 55 хувийг Ц. Элбэгдоржид, 26 хувийг Б: Бат-Эрдэнэд, 19 хувийг Н.Удвалд өгсөн байна. ТВ5-ын хандлага үүнтэй төстэй байна; 43 хувийг Ц. Элбэгдоржид, 29 хувийг Б: Бат-Эрдэнэд, 28 хувийг Н.Удвалд тус тус зориулсан байна. Эдгээр тоо хэмжээнд зохион байгуулалтын хувь ороогүй зөвхөн мэдээний хөтөлбөрөөр гарсан сонгуулийн сурталчилгаа юм.

сэргээх дээр ЕАБХАБ-ын зарчим, олон улсын туршлагатай нийцэхгүй байна.⁴⁰ Цаашилбал оролцогч талууд сонгуулийн маргаан шийдвэрлэх үйл явц дээр нэгдмэл ойлголтгүй, энэхүү үйл явцын тухай тайлбар нэг мөр биш байв. Сонгуультай холбоотой гомдол гарсан тохиолдолд эрх бүхий байгууллагууд шударга, үр дүнтэй ажиллаж чадах эсэх дээр улс төрийн нэг нам эргэлзэж байсан.

МУЕСТХ-ийн дагуу сонгуулийн хорооны шийдвэрийг дээд шатных нь сонгуулийн хороонд давж заалдах боломжтой бөгөөд дээд шатны сонгуулийн хороо гурав хоногийн дотор шийдэх ёстой. Шүүхийн эрх мэдлийг зохицуулах хуулиудын дагуу сонгуультай холбоотой асуудлаар шүүхэд мөн нэхэмжлэл гаргах боломжтой ба ингэхэд асуудлыг хуулиар тогтоосон хугацаанд шийдвэрлэх ёстой.⁴¹ Шүүхэд гомдол гаргасан тохиолдолд хянан шийдвэрлэх хугацаа нь хэд хэдэн сар болох боломжтой тул энэ нь ЕАБХАБ-ын 1990 оны Копенгагены баримтын 5.10-т заасны дагуу сонгуулийн тухай өргөдөл гомдлыг сонгуулийн хугацаанд багтаан хурдан шуурхай, үр дүнтэй шийдвэрлэх зарчмыг хэрэгжүүлэх боломжгүй байна гэсэн дүр зургийг бүрдүүлж байна.⁴² Хэдий тийм ч энэ сонгуулиар шүүх нэг биш хэргийг шуурхай шийдвэрлэлээ.

ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ нь СЕХ-нд болон цагдаагийн байгууллагад ирсэн бүх өргөдөл гомдолтой бүрэн танилцах боломжоор хангагдсангүй. СЕХ-нд ирүүлсэн гомдлуудын ихэнх нь сонгуулийн хороодын бүрэлдэхүүнтэй холбоотой байв. СЕХ эдгээр гомдлыг барагдуулсан байдал дээр МАН шүүмжлэлтэй хандаж, СЕХ-ны шийдвэрүүдээ хараат байдлаар гаргалаа гэв.⁴³ Цагдаагийн байгууллага болон Шударга өрсөлдөөн, хэрэглэгчдийн төлөө газарт ирсэн олон гомдлууд сонгуулийн сурталчилгааны хуулийг зөрчсөн тухай байв.

Иргэд ба Олон улсын ажиглагчид

МУЕСТХ-ийн дагуу дотоодын болон олон улсын ажиглалт хийхийг зөвшөөрдөг. Улс төрийн нам, эвсэл, ТББ-ын зүгээс 4 хүртэлх хүнийг төлөөлүүлэн СХХ-нд ажиглалт хийлгэх эрхтэй. Хэрэв хэсгийн хороо нь бүх ажиглагчдыг оролцуулах боломжгүй тохиолдолд СХХ нь байгууллага бүрээс хамгийн багадаа хоёр ажиглагчийг ажиллаж боломж олгоно. Дотоодын ажиглалтыг эхний ээлжинд улс төрийн нам болон нэр дэвшигчийн ажиглагчид хийсэн. Иргэний нийгмийн байгууллагууд сонгуулийн санал авах өдрөөс өмнөх хугацаа болон сонгуулийн санал

⁴⁰ ЕАБХАБ-ын 1991 оны Москвагийн баримт бичгийн 18 дугаар хэсэгт ЕАБХАБ-ын бүрэн эрхт гишүүн орнуудын “захиргааны шийдвэрийн эсрэг авч хэрэгжүүлэх үр дүнтэй арга хэрэгслээр хангах” үүрэгтэй гэж заасан. Венецийн комиссийн Сонгуультай холбоотой асуудлууд дахь сайн туршлагын тухай зааврын 3.3(с) заалтыг үзнэ үү. Үүний 11-р хуудсанд “Өргөдөл гомдол гаргах журам, ялангуяа эрх бүхий этгээдийн эрх мэдэл, үүрэг хариуцлагыг хуулиар сайн зохицуулах хэрэгтэй. Ингэснээр шүүх эрх мэдэл хэрэгжих газар нутгын талаарх маргаан, зөрчилдөөнөөс зайлсхийх (эерэг эсвэл сөрөг байдлаар) ба Өргөдөл гомдол гаргагч, эрх бүхий байгууллагын аль нь ч гомдол гаргах байгууллагыг сонгохгүй” гэж заасан ба үүнийг [http://www.venice.coe.int/docs/2002/CDL-AD\(2002\)023-e.pdf](http://www.venice.coe.int/docs/2002/CDL-AD(2002)023-e.pdf). –ыг үзнэ үү.

⁴¹ Иргэний болон эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуульд заасны дагуу шүүх хэргийг 60 хоногт багтаан хянан шийдвэрлэх ба давж заалдах гомдол гарсан хэргийг шүүх хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан хянан шийдвэрлэнэ. Цаашлаад 7-14 хоногийн хугацаанд мөрдөн шалгана. Эдгээр хуулийн хугацаанаас болоод өнөөдрийг хүртэл цагдаагийн байгууллагаар шалгагдсан өргөдөл гомдлоос шүүхэд хянан шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн хэрэг байхгүй байна. Сонгуультай холбоотой эрүүгийн шинжтэй хэдхэн хэрэгт хялбаршуулсан журмаар эрүүгийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэдэг.

⁴² ЕАБХАБ-ын 1990 оны Копенгагены баримт бичгийн 5.10-т “захиргааны шийдвэрийн эсрэг авч хэрэгжүүлэх үр дүнтэй арга хэрэгслийг” хүн бүр эрэлхийлэх эрхтэй ба “ингэснээр үндсэн эрхийг хүндлэн дээдлэх зарчмыг баталгаажуулах ба хууль эрх зүйн шударга байдлыг хангана” гэж заасан.

⁴³ Нийт 39 гомдол сонгуулийн хороодын бүрэлдэхүүнтэй холбоотой байна. Үүнд СЕХ хариулахдаа сонгуулийн хороодын гишүүнээр батлагдсан хүмүүсийн жагсаалтыг өгсөн ба ямар үндэслэлээр бусад хүмүүсийг сонгохоос татгалзсан болох, гишүүнээр сонгогдсон хүмүүст ямар шалгуур тависан болохыг дурдаагүй байна. Бусад хариултууд гомдлын гол мөн чанар, агуулгад хамааралгүй байсан ба нэг хариултанд СЕХ-ны бүрэн эрхийн хүрээнд байгаа асуудлуудад хөндлөнгөөс оролцохоо зогсоохыг хүссэн байв.

авах өдрийг ажиглаагүй. Энэ нь нэг талаар санхүүгийн боломжгүй байдал, нөгөө талаас сонгуулийн санал авах өдрөөс өмнөх хугацаанд мониторинг хийхийг хязгаарласан СЕХ-ны шийдвэртэй холбоотой.⁴⁴ Сонгуулийн санал авах өдөр хийсэн ажиглалтаас харахад хэсгийн хороод дээр хязгаарлагдмал тооны дотоодын ажиглагчид байлаа. “МИДАС” ТББ санаачлан СТАТ-ыг СЕХ-ны байранд шалгаж туршилт хийсэн ба энэ үед улс төрийн намуудын төлөөлөл, хэвлэл мэдээлэл, ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-ныг байлцуулсан болно.

Сонгуулийн санал авах өдөр

Сонгуулийн санал авах өдөр тайван, амгалан болж өнгөрлөө. Сонгуулийн ирц 64.8 хувьтай байлаа. СЕХ-ноос сонгуулийн урьдчилсан дүнг 6 сарын 27-ны өдөр мэдээлсэн бөгөөд үүнийг хэсгийн хороод дээр задлаагүй болно.

ЕАБХАБ-ын АИХЭГ-ын ажиглагчдын ажиглалт хийсэн 72 хэсгийн хорооны 3-аас бусад хэсгийн хороодын нээлтийн үйл явцыг эерэгээр дүгнэлээ. МУЕСТХ-иар сонгогчид саналаа өгч эхлэх болон СХХ сүүлчийн бэлтгэл ажлаа хангахаар уулзах цаг хугацааг хоёуланг нь өглөөний 07.00 цаг гэж тогтоосноос болж ажиглалт хийгдсэн санал авах байрнуудын 42 нь цагтаа нээгдээгүй болно.

Ажиглалт хийгдсэн санал авах байрнуудын 99 хувь нь эерэг үнэлгээ авлаа. Холбогдох процедурыг ерөнхийдөө дагаж мөрдсөн боловч сонгогч нууцаар саналаа гаргах боломж зуун хувь хангагдаагүй (10 хувь) ба ялангуяа 6 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан зөөврийн битүүмжилсэн саналын хайрцагаар санал авах үед (ажиглалтын 70-аас 29-д) хангагдсангүй. Иргэний бүртгэлийн мэдээллийг шалгах болон хурууны хээ уншуулах ажил журмын дагуу явагдсан ба ажиглалт хийгдсэн сонгуулийн санал авах байрнуудаас таван хувьд нь нэг ба түүнээс дээш тооны сонгогчид сонгогчдын нэрсийн жагсаалтанд нэр нь байхгүйгээс болж саналаа өгч чадалгүй буцаж байв. ЕАБХАБ-ын АИХЭГ-ын ажиглагчид хурууны хээ уншуулалт болон СТАТ-тай холбоотойгоор гарсан техникийн асуудлуудын талаар үе үе мэдээлж байв.

СХХ-дын гишүүдийн 77 хувь нь эмэгтэй ба ажиглалт хийгдсэн сонгуулийн санал авах байрнуудын дарга нарын 56 хувь нь эмэгтэй хүн байлаа. Ажиглалт хийгдсэн сонгуулийн санал авах бараг бүх байранд нэр дэвшигчдийн төлөөлөгчид байсан ба ажиглагч иргэд 11 хувийг эзэлж байв. Сонгуулийн санал авах байрнуудын талаас дээшид нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан байгууламж бэлэн болоогүй байсан бөгөөд санал авах байрнуудын 26 хувь эдгээр сонгогчдод тохиромжгүй байдлаар засагдсан байв. Харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулан саналын хуудсыг унших, саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайль үсэг бүхий хавтсаар ихэнхдээ хангах боломжгүй байлаа. Ажиглалт хийгдсэн сонгуулийн санал авах байрнуудын цөөн тооных (хоёр хувь) нь зай муутай, сонгогчид ихээр чихэлдэж байсан нь сонгогчид саналаа өгөхөд тохиромжгүй байв.

Ажиглалт хийсэн 80 хэсгийн хороодын 6-аас бусдад нь сонгуулийн санал тоолох ажлын үйл явцыг эерэгээр дүгнэлээ. ЕАБХАБ-ын АИХЭГ-ын САХ-ны ажиглагчид процедурын зарим нэг зөрчлийг, жишээлбэл СХХ-д журамд заасан бүх дарааллыг баримтлахгүй байх зэргийг тэмдэглэсэн. Олгосон саналын хуудасны тоог хурууны хээгээ уншуулж, иргэний цахим үнэмлэхнийхээ мэдээллийг баталгаажуулсан сонгогчдын тоотой харьцуулан тулгахыг ихэнхдээ хийгээгүй. Хэрэв үүнийг хийсэн бол энэ нь болзошгүй хууль бус үйлдлийн эсрэг нэмэлт хамгаалалт болж чадах байлаа. ЕАБХАБ-ын АИХЭГ-ын САХ-ны ажиглагчид СТАТ-ны мэдээний хуулбарыг авах эрхтэй байсан боловч хуулбарыг тэдэнд өгөөгүй болно. Ажиглалт

⁴⁴ СЕХ-ны 23 дугаарт шийдвэрийн 2.2 зүйлд “ТББ-ууд сонгуулийн санал авах өдөр зарлагдсанаас хойш 15 өдрийн дотор сонгуульд хяналт тавих хүсэлтээ бичгээр гаргах ” гэж заасан. (жишээлбэл: сонгуулийн санал авах өдрөөс 50 хоногийн өмнө)

хийгдсэн 21 тооллогын үеэр СХХ-д тэмдэглэлээ бичиж дуусгахдаа бэрхшээлтэй байв. Ажиглалт хийгдсэн 16 сонгуулийн санал авах байрнуудын ихэнхэд нь СТАТ-ны дүнг гараар явуулсан тооллоготой тулгав.

СДСХ-ны хүснэгт гаргах үйл явцыг ЕАБХАБ-ын АИХЭГ-ын САХ-ны ажиглагчид 59 сонгуулийн санал авах байран дээр ажишласан ба тэдгээрийн 20 нь зохион байгуулалт, ил тод бус байдлаасаа болон сөрөг үнэлгээ авсан. Очиж үзсэн СДСХ-ны санал авах байрнуудын тал нь сонгогчдыг хүлээн авах болон үйл ажиллагаа явуулахад тохиромжгүй байснаас болж хүмүүс чихэлдэх, үйл явцыг ил тод харуулахад сөргөөр нөлөөлж байлаа. Процедурьг дийлэнхидээ дагаж мөрдөж байсан боловч СХХ-дын протокол хөтлөлттэй холбоотой зарим асуудлыг, тухайлбал бүрэн гүйцэд хөтлөхгүй байх, буруу бөглөх зэргийг ажиглагчид анзаарсан байна. Зарим ажиглагчдын ажиглалт хийхийг нь хориглож хязгаарласан байна.

*Зөвхөн Англи хэл дээрх хувилбар нь албан ёсны баримт бичиг болно.
Гэхдээ энэхүү мэдэгдлийн албан бус орчуулгыг Монгол хэл дээр авах боломжтой.*

ХОРООНЫ МЭДЭЭЛЭЛ БА ТАЛАРХАЛ

ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ нь 5 дугаар сарын 10-ны өдөр нийслэлд ажиллах 14 шинжээчийн бүрэлдэхүүнтэй Улаанбаатар хотноо нээгдсэн ба урт хугацааны 24 ажиглагчийг Монгол орны өнцөг булан бүрт томилон ажиллуулсан.

Сонгуулийн санал хураах өдөр богино хугацааны 167 ажиглагчийг нэмж томилсон бөгөөд ЕАБХАБ-ын гишүүн улс орнуудаас нийт 33 орны ажиглагчид ирсэн. 16 аймаг болон Улаанбаатар хотын бүх 9 дүүрэг дэхь сонгуулийн санал авах нийт 1,896 хэсгийн хороодын 659-д нь ажиглагчид сонгуулийн санал хураалтыг ажигласан. 16 аймаг болон Улаанбаатар хотын бүх 9 дүүргийн 81 сонгуулийн хэсгийн хороодын санал тоолох үйл явцыг ажиглав. Ажиглагчид 339 СДСХ-дын 35 хорооны саналын үр дүнг гаргах үйл явцын тухай 59 тайланг гаргав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг ажиглах урилга ирүүлсэн Монгол Улсын эрх бүхий байгууллагууд, хамтран ажиллаж, итгэмжлэл олгосон Сонгуулийн Ерөнхий Хороо, Монгол Улсын Гадаад харилцааны яам болон туслалцаа дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан бүх байгууллагуудад талархлаа илэрхийлье. Түүнчлэн ажиглагчидтай хамтран ажиллаж, дэмжлэг туслалцаа үзүүлсэн Монгол Улсад суугаа Элчин сайдын яамд болон олон улсын байгууллагуудад мөн талархсанаа илэрхийлж байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг дараах хүмүүстэй холбогдон авна уу:

- Улаанбаатар хот дахь ЕАБХАБ-ын АИХЭГ-ын САХ-ны дарга, Элчин сайд хатагтай Одри Гловер, (+976-70-009010);
- Варшав хот дахь ЕАБХАБ-ын АИХЭГ-ын хэвлэл мэдээлэл хариуцсан эрхлэгч, хатагтай Лорен Барановска, (+48-695-916 998); мөн ЕАБХАБ-ын АИХЭГ-ын Сонгуулийн зөвлөх ноён. Александр Шлик (+48-22-520 0600).

ЕАБХАБ-ЫН АИХЭГ-ААС ТОМИЛОГДСОН СОНГУУЛЬ АЖИГЛАХ ХОРОО ХАЯГ:

Монгол Улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо
Нарны зам 87, 4 дүгээр давхар
Утас: +976-70-009010
Факс: +976-70-008010

Э-шуудан: office@odhr.mn

Цахим хуудас: www.osce.org/odhr/elections/101349